



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 18 өдөр

Дугаар А/582

Ховд


Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны “Аймгийн 2021 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 4/03 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 2021 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 91 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд “COVID-19”-ын цар тахалтай тэмцэх арга хэмжээг зохион байгуулж буй “Нэг цэгийн үйлчилгээ”-ний бэлтгэл бэлэн байдлыг хангаж түргэвчилсэн тестийн шинжилгээний оношлуурын нөөц бүрдүүлэх санхүүжилтэд 60 000 000 төгрөг /жаран сая/-ийг хавсралтаар баталж зарцуулсугай.


2. Тус арга хэмжээнд зарцуулах 60 000 000 төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн 2021 онд батлагдсан төсвөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны  
10 дугаар сарын 18-ны өдрийн  
А/582 дугаар захирамжийн хавсралт



**“НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ”-НИЙ БЭЛТГЭЛ БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ,  
ТҮРГЭВЧИЛСЭН ТЕСТИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ОНОШЛУУРЫН НӨӨЦ  
БҮРДҮҮЛЭХ САНХҮҮЖИЛТ**

Д/д	Хүлээн авах байгууллагын нэр	Нийлүүлэх байгууллагын нэр	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Нийт дүн /мянган төгрөг/
1.	Эрүүл мэндийн газар	“Хос шүүдэргэнэ” ХХК гэрээ	5000	12 000 000	60 000 000
Нийт дүн			5000		60 000 000

-оОо-